



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/1058

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх зорилгоор “Иргэний нисэхийн ерөнхий газрын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр” болон “Иргэний нисэхийн ерөнхий газрын хүний нөөцийг 2020-2024 он хүртэл хөгжүүлэх чиглэл болон төлөвлөгөө”-г нэгдүгээр хавсралтаар баталсугай.


2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг байгууллагын жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ч.Нямсүрэн/-т үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Т.Батжаргал/-т, Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллахыг Дотоод аудитын алба /Н.Мөнхсүрэн/-нд тус тус даалгасугай.


4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2015 оны А/833 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Л.БЯМБАСҮРЭН



Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2019 оны № дугаар сарын 20-ны өдрийн
А/1038 дугаар тушаалын хавсралт



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР**

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА	3
1.1 Хөтөлбөр боловсруулах үндэслэл.....	3
1.2 Хөтөлбөрийн хамрах хүрээ.....	5
ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	5
ГУРАВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	7
ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	8
ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, САНХҮҮЖИЛТ	11
ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙГ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ	11

Handwritten red text on the right margin.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

1.1 Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 1.2.5-д “Салбарын хөгжлийн шаардлагыг хангахуйц мэдлэг, чадвар, туршлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэх”, 8.1.1-д “Иргэний нисэхийн нарийн мэргэжлийн болон бусад ажилтныг өндөр хөгжилтэй, үндсэн англи хэлтэй улс оронд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын байгууллагад бэлтгэх”, “8.1.2. Бэлтгэгдсэн мэргэжилтэй боловсон хүчнийг олон улсын стандарт, шаардлага, өөрийн орны онцлог, эрх зүйн орчинд нийцүүлэн дадлагажуулах, ур чадварыг хадгалах, давтан сургалт болон дахин мэргэшүүлэх сургалтад хамруулж, хөгжүүлэхэд чиглэсэн үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх” болон Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт “Салбарынхаа хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх” гэж тусгагдсан билээ.

Мөн ICAO-аас эрчимтэй өсөн нэмэгдэж буй зорчигч урсгал болон нислэгийн хөдөлгөөний идэвхжил нь олон улсын хэмжээнд иргэний нисэхийн салбарт ойрын хугацаанд тулгарах томоохон сорилт болохыг онцолсон бөгөөд 2010 онд тус байгууллагаас гүйцэтгэсэн судалгаагаар Ази, Номхон далайн бүс нь 2030 он гэхэд дэлхийн нийт нислэгийн 32%-ийг бүрдүүлэхээр байгааг тогтоосон.⁵ Дээрх сорилтыг даван туулах зорилгоор 2016 онд зохион байгуулагдсан ICAO-ын 39 дэх Ассамблейн хурлаас А39-29⁶ “Дараа үеийн нисэхийн мэргэжилтнүүд” дугаар бүхий тогтоол гарч ICAO-ын гишүүн улсуудыг ирээдүйд шаардагдах мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх чадавхаа сайжруулах, хүний нөөцийн хэрэгцээгээ урт хугацаанд тодорхойлохыг онцгойлон анхааруулсан болно.

⁵ DOC9956 “Global and Regional 20-year Forecasts” International Civil Aviation Organization, 52-р нүүр

Өнөөгийн байдал:

Иргэний нисэхийн ерөнхий газар нь гадаадын нисэхийн мэргэжлийн сургалтын байгууллагад зохион байгуулагдаж буй сургалт болон Иргэний нисэхийн ерөнхий газрын нисэхийн сургалтын төвийн танхимын сургалтаар ажилтнуудыг сургаж дадлагажуулж байгаа бөгөөд 2014-2018 оны байдлаар байгууллагын тухайн жилийн нийт төсвийн 1.8%-ийг зарцуулсан байна.

2014-2018 онуудад давхардсан тоогоор гадаадын сургалтын байгууллагуудад мэргэшүүлэх, сертификатын, богино хугацааны, хичээл үйлдвэрлэлийн болон тэтгэлэгт богино хугацааны сургалтуудад 1012 ажилтан, дотоодын сургалтын байгууллагуудад давхардсан тоогоор нийт 1736 ажилтан, нисэхийн сургалтын төвд зохион байгуулагдсан анхан, давтан, хөгжүүлэх, мэдээлэл олгох, танилцах, дадлагажуулах, сертификатын сургалтуудад давхардсан тоогоор нийт 10470 ажилтнуудыг хамруулсан байна. Мөн сургалтад оруулж буй хөрөнгө оруулалтын хувьд ИНЕГ нь 2014-2018 оны хугацаанд нийт 144 иргэнийг урт хугацааны буюу 10 сараас 5 хүртэлх жилийн хугацаатайгаар АНУ, Канад, ОХУ, Тайландын Вант Улс, Япон, Украйн, Франц, ИБУИНВУ, Австрали, БНХАУ, БНСУ улсуудад мэргэжил эзэмшүүлэх сургалтуудад хамруулан хөрөнгө оруулалт хийсэн.

Боловсролын байдлаар нь ИНЕГ болон харьяа нэгжүүдийг жагсаавал:

/2019 оны 12 дугаар сарын байдлаар/

Боловсролын байдал	Агентлаг	ИНЕГ үйлдвэрлэл	СЗА	НХУА	НМУА	НЖБА	ХНАА	НУТА	НБУГ	ЧХОУНБ	ГТУА	АБХА	УБХОУШНБ АӨЗА	Орон нутаг	Нийт
Доктор	0			0			0	-	0		0	0		2	2
Магистр	44	20	2	20	6	15	29	5	22	29	10	9	18	20	249
Бакалавр	59	86	15	156	50	14	198	23	50	238	88	190	130	180	1477
Тусгай дунд	2	9	7	23	2		6	-	0	53	60	18	16	86	282
Бүрэн дунд	0	13	7	32	3		5	1	0	99	85	82	6	91	424
Бүрэн бус дунд	0			3			0	-	0	22	25	2		14	66
НИЙТ	105	128	31	234	61	29	238	29	72	441	268	301	170	393	2500

ИНЕГ-аас ажилтнуудын мэргэжил, ур чадварыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Харьяа салбар, нэгжүүдээс ирүүлсэн саналыг үндэслэн жил бүр гадаад, дотоод сургалтын төлөвлөгөө, төсвийг батлуулж, хэрэгжүүлдэг
- Олон улсын болон дотоодын хурал, семинарт тогтмол хамруулдаг
- Үйлдвэрлэлийн давтан сургалтуудад ажилтнуудыг тогтмол хамруулдаг
- Ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх сургалтуудыг байгууллагадаа тогтмол зохион байгуулдаг.

Гэвч хэрэгцээт мэргэжлийн хүний нөөцийг тодорхойлоход:

- Агаарын тээврийн үзүүлэлтүүдийг харгалзан үздэггүй
- Ажлын байрны шинжилгээ хийгддэггүйгээс шалтгаалж сургалтын хэрэгцээг оновчтой тодорхойлдоггүй.
- Урт хугацаанд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөг боловсруулаагүй.
- Иргэний нисэхийн салбарт шаардлагатай хүний нөөцийн судалгаа хийгдээгүй.

Иймд хүний нөөцийн эрэлт хэрэгцээг тодорхойлж, мэргэжлийн хүний нөөцийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.2 Хөтөлбөрийн хамрах хүрээ

Энэхүү хөтөлбөр нь ИНЕГ, түүний харьяа алба салбар нэгжийн мэргэжлийн хүний нөөцийг сургаж бэлтгэх, мэргэжил ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, дадлагажуулах, давтан сургах болон шинээр салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх үйл ажиллагааг хамарна.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

ИНЕГ-ын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр /цаашид Хөтөлбөр гэх/-ийн зорилго нь Олон улсын иргэний нисэхийн өнөөгийн ба ойрын ирээдүйн хөгжлийн чиг хандлага, дотоод зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж, хүний нөөцийг төлөвлөх, дараа үеийн залгамж халаа мэргэшсэн ажилтнуудыг бэлтгэх, ажилтнуудыг давтан сургахад шаардлагатай мэргэжлийн чиг баримжааг тодорхойлж сургалтын тогтолцоог бий болгоход оршино.

Энэхүү хөтөлбөрийг дараах 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

Зорилт 1: Байгууллагын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, эрэлт хэрэгцээ болон агаарын тээврийн зах зээлийн хөгжил, өсөлтөд үндэслэн цаашид шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.1 Монгол Улсын иргэний агаарын тээврийн зах зээлийн өсөлт, нислэг хөдөлгөөний идэвхжилтэй холбогдуулан цаашид шаардлагатай мэргэжлийн хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг 2 жил тутамд нэг удаа тодорхойлж, ирэх 5 жилд бэлтгэх шаардлагатай мэргэжлийн жагсаалтыг гаргах, шинэчлэх

1.2 Хүний нөөцийн эрэлт хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх,

1.3 Засгийн газрын тэтгэлэг, боловсролын зээлийн сан, байгууллагын болон хувийн зардлаар иргэний нисэхийн үндсэн мэргэжлээр сурч мэргэжил эзэмшсэн оюутнуудын судалгааг гаргаж, шинээр бэлтгэх мэргэжлийн жагсаалттай уялдуулах,

1.4 Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ИНЕГ-ын хүний нөөц сургалт хариуцсан нэгж нь гадаад хамтын ажиллагаа хариуцсан нэгжтэй хамтран гадаадын сургалтын байгууллагатай тогтмол хамтарч ажиллах бөгөөд ажилтныг мэргэжлийн дагуу зохих сургалтад хамруулах, нисэхийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх чиглэлээр Харилцан ойлголцлын санамж бичиг болон түүнтэй адилтгах эрх зүйн баримт бичиг байгуулах,

1.5 Иргэний нисэхийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх чиглэлээр дотоодын их, дээд сургуулиудтай хамтран ажиллах, хамтын ажиллагааг өргөжүүлэх

Зорилт 2: ИНЕГ болон түүний харьяа салбар, нэгжийн ажилтнуудыг мэргэшүүлэх, мэргэжил ур чадварыг дээшлүүлэх;

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.1 Хүний нөөц, сургалт хариуцсан нэгж нь газар болон харьяа нэгжүүдэд ажлын байрны шинжилгээг хийж, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж мэргэшүүлэх сургалтад хамруулах,

2.2 Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт хариуцсан нэгж нь харьяа байцаагч нарын хамрагдах сургалтыг ICAO-аас батлагдсан баримт бичиг, Иргэний нисэхийн дүрмээр тогтоосон шаардлагад нийцүүлэн боловсруулж, сургалтын төлөвлөгөө боловсруулан ИНЕГ-ын даргаар батлуулах, /Байцаагчийн чадварын сургалтын зааврыг баримтлах/

2.3 Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн иргэний нисэхийн мэргэжил боловсрол олгодог их дээд сургууль, коллеж болон сургалтын байгууллагад мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, ажилтнуудаа дадлагажуулах, давтан сургах, мэргэшүүлэх

2.4 Ажлын болон ажлын бус цагаар эчнээ болон оройгоор, гарагийн сургалтаар мэдлэг боловсролоо дээшлүүлж байгаа ажилтнуудыг дэмжиж, суралцах нөхцөл боломжоор хангах

2.5 Иргэний нисэхийн үндсэн мэргэжлийн ажлын байранд ажиллаж байгаа дадлага, туршлага бүхий ажилтныг тэтгэвэрт гарахаас өмнөх 3 жилийн хугацаанд тухайн ажлын байрны залгамж халааг урьдчилан сургаж, бэлтгэдэг байх тогтолцоог бий болгох

2.6 Мэргэшсэн байдлын мэдээллийн санг бий болгох, дүн шинжилгээ хийх тогтолцоог бүрдүүлэх

Зорилт 3: Нисэхийн сургалтын төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, хүчин чадавхыг нэмэгдүүлж ажилтнуудыг бэлтгэх, сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх, танхимын болон зайн сургалтын чиглэлүүдийг нэмэгдүүлэх болон хөтөлбөрийг сайжруулах замаар олон улсын хэмжээнд сертификатын болон боловсролын зэрэг олгох сургалт явуулах бааз суурийг бүрдүүлж, үйл ажиллагааг нь өргөжүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.1 Нисэхийн сургалтын төвийг Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын байгууллага болгох, хүний нөөцийг дотооддоо мэргэшүүлэх арга хэмжээг үе шаттайгаар төлөвлөж, зохион байгуулах

3.2 Нисэхийн мэргэжлийн багшлагч мэргэжилтэн, заах арга зүйч багш нарын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх

3.3 Нисэхийн сургалтын төвийн сургалтын техник, тоног төхөөрөмж технологийг шинэчлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх, сургалтын таатай орчинг бий болгох

3.4 Нисэхийн сургалтын төвийн номын сангийн сан хөмрөгийг баяжуулж сайжруулах, цахимжуулах

3.5 Хөтөлбөрийг боловсронгуй болгох, олон улсын стандартад нийцүүлж сайжруулах

Зорилт 4: ИНЕГ, салбар нэгжүүдийн мэргэшсэн ажилтны залгамж халааг тогтмол бэлтгэх зорилгоор байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг тогтмолжуулах;

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

4.1 “Нисэхийн мэргэжил сурталчлах өдөрлөг”-ийг олон нийтэд нээлттэйгээр жилд 1-2 удаа зохион байгуулах,

4.2 Шинээр ажилтан ажилд авах үйл ажиллагаанд мөрдөгдөх “Сонгон шалгаруулалтын журам”-ыг байгууллагын цахим хуудсанд байршуулах,

4.3 Шинээр ажилтан авах болон ажлын байрны сул орон тоонд сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил тод, нээлттэй зарлах,

4.4 Салбарын ажилтнуудын амжилт, шинэ санаа, судалгаа шинжилгээний ажил, бүтээлч ажлыг байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах,

4.5 Шинэ боловсон хүчин бэлтгэхтэй холбоотой сургалтын зарын тухай мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж ил тод, нээлттэй зарлах,

ГУРАВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1 ИНЕГ болон түүний харьяа алба салбар, нэгжийн хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан нь ажилтнуудын сургалтад хамрагдсан мэдээлэл, гаргасан амжилт болон бусад хүний нөөцөд холбогдох мэдээллийг хүний нөөцийн мэдээллийн санд тогтмол оруулж, бүртгэлийг тухай бүр баяжуулж ажиллана.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Хүрэх үр дүн	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
1	Хүний нөөцийн эрэлт хэрэгцээг 2 жил тутамд 1 удаа тодорхойлж, 5 жилд бэлтгэх мэргэжлийн жагсаалтыг гаргах	Шаардлагатай хүний нөөцийн эрэлт хэрэгцээг жил бүр тодорхойлдог.	Салбарын хүний нөөцөд шаардагдах мэргэжилтний эрэлт хэрэгцээнд суурилсан 5 жилд бэлтгэх мэргэжлийн жагсаалт гарсаж тодорхойлсон байна.	Салбарын хүний нөөцөд шаардагдах мэргэжилтний эрэлт хэрэгцээнд суурилсан 5 жилд бэлтгэх мэргэжлийн жагсаалт гаргасан байна.	Салбарын хүний нөөцөд шаардагдах мэргэжилтний эрэлт хэрэгцээнд суурилсан 5 жилд бэлтгэх мэргэжлийн жагсаалт гаргаж шинэчилсэн байна.	Салбарын хүний нөөцөд шаардагдах мэргэжилтний эрэлт хэрэгцээнд суурилсан 5 жилд бэлтгэх мэргэжлийн жагсаалтын судалгааг хийсэн байна.	Салбарын хүний нөөцөд шаардагдах мэргэжилтний эрэлт хэрэгцээнд суурилсан 5 жилд бэлтгэх мэргэжлийн жагсаалт гаргаж шинэчилсэн байна.	
2	Жилд 2 болон түүнээс дээш гадны болон дотоодын их сургууль, сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулах	2019 оны байдлаар гадны 2 байгууллага, дотоодын 8 сургалтын байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан.	2020-2024 онд шинээр гадаадын сургалтын 10 байгууллагатай, дотоодын 9 байгууллагатай хамтран ажиллах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх гэрээ байгуулсан байна.	2020 онд шинээр гадаадын сургалтын 2 байгууллагатай, дотоодын сургалтын 2 байгууллагатай хамтран ажиллах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх гэрээ байгуулсан байна.	2021 онд шинээр гадаадын сургалтын 2 байгууллагатай, дотоодын сургалтын 2 байгууллагатай хамтран ажиллах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх гэрээ байгуулсан байна.	2022 онд шинээр гадаадын сургалтын 2 байгууллагатай, дотоодын сургалтын 2 байгууллагатай хамтран ажиллах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх гэрээ байгуулсан байна.	2023 онд шинээр гадаадын сургалтын 2 байгууллагатай, дотоодын сургалтын 2 байгууллагатай хамтран ажиллах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх гэрээ байгуулсан байна.	2024 онд шинээр гадаадын сургалтын 2 байгууллагатай, дотоодын сургалтын 1 байгууллагатай хамтран ажиллах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх гэрээ байгуулсан байна.
3	Шинэ боловсон хүчин бэлтгэх, төлөвлөгөөний дагуу жилд 20-оос доошгүй боловсон хүчин бэлтгэх гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах	2013-2018 онуудад ИНЕГ-ын зардлаар гадаад улс оронд суралцахаар 119 хүн гэрээ байгуулсан бөгөөд 2008-2018 онуудад нийт 141 оюутан төгссөн.	Ажлын хэрэгцээ шаардлагад тулгуурлан 2020-2024 онд иргэний нисэхийн зардлаар 100-аас доошгүй шинэ боловсон хүчин бэлтгэх гэрээ байгуулж ажилласан байна.	Шинээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, сургах төлөвлөгөөний дагуу ажлын хэрэгцээ шаардлагад тулгуурлан 2020-2024 онд иргэний нисэхийн зардлаар 100-аас доошгүй шинэ боловсон хүчин бэлтгэх гэрээ байгуулж ажилласан байна.				

<p>2014-2018 онуудад давхардсан тоогоор гадаадын сургалтын байгууллагуудад мэргэшүүлэх, богино хугацааны сургалтуудад 1012 ажилтан, дотоодын сургалтын байгууллагуудад давхардсан тоогоор нийт 1736 ажилтан, нисэхийн сургалтын төвд давхардсан тоогоор нийт 10470 ажилтнуудыг хамруулсан.</p>	<p>Ажлын байрны шинжилгээг хийж, сургалтын хэрэгцээ шаардлагыг үндэслэн гадаадын байгууллагад жилд 150 болон түүнээс дээш ажилтнуудыг, дотоодын сургалтын байгууллагуудад жилд 200 болон түүнээс дээш ажилтнуудыг, нисэхийн сургалтын төвд жилд 200 болон түүнээс дээш ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна.</p>	<p>Ажлын байрны шинжилгээг хийж, сургалтын хэрэгцээ шаардлагыг үндэслэн гадаадын байгууллагад жилд 150 болон түүнээс дээш ажилтнуудыг, дотоодын сургалтын байгууллагуудад жилд 200 болон түүнээс дээш ажилтнуудыг, нисэхийн сургалтын төвд жилд 200 болон түүнээс дээш ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна.</p>	<p>Ажлын байрны шинжилгээг хийж, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, урт хугацааны /2021-2030/ сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулна.</p>	<p>Урт хугацааны сургалтын төлөвлөгөөнд үндэслэн гадаадын байгууллагад 150 болон түүнээс дээш ажилтнуудыг, дотоодын сургалтын байгууллагуудад 200 болон түүнээс дээш ажилтнуудыг, нисэхийн сургалтын төвд 200 болон түүнээс дээш ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтад хамруулна.</p>	<p>Урт хугацааны сургалтын төлөвлөгөөнд үндэслэн гадаадын байгууллагуудад 150 болон түүнээс дээш ажилтнуудыг, нисэхийн сургалтын төвд 200 болон түүнээс дээш ажилтнуудыг, хамруулна.</p>	<p>Сургалтын төлөвлөгөөг шинэчлэх, дахин нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулна. Мөн урт хугацааны сургалтын төлөвлөгөөнд үндэслэн гадаадын байгууллагад 150 болон түүнээс дээш ажилтнуудыг, дотоодын сургалтын байгууллагуудад 200 болон түүнээс дээш ажилтнуудыг, нисэхийн сургалтын төвд 200 болон түүнээс дээш ажилтнуудыг, хамруулна.</p>	<p>Урт хугацааны сургалтын төлөвлөгөөнд үндэслэн гадаадын байгууллагад 150 болон түүнээс дээш ажилтнуудыг, дотоодын сургалтын байгууллагуудад 200 болон түүнээс дээш ажилтнуудыг, нисэхийн сургалтын төвд 200 болон түүнээс дээш ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтад хамруулна.</p>
<p>Нисэхийн сургалтын төвийг Ази номхон далайн бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх сургалтын төв болгож жилд 2-оос доошгүй гадаадын сертификаттай зохион байгуулах.</p>	<p>Нисэхийн сургалтын төвийн сургалтын техник, тоног төхөөрөмж технологийг шинэчлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх, сургалтын таатай орчинг бий болгож, Олон улсын сургалтын төвийн стандарт нийцсэн байна.</p>	<p>Нисэхийн сургалтын төвийн сургалтын техник, тоног төхөөрөмж технологийг шинэчлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх, сургалтын таатай орчинг бий болгох талаар удирдлагад танилцуулж шийдвэр гаргуулсан байна.</p>	<p>Нисэхийн сургалтын төвийн сургалтын техник, тоног төхөөрөмж технологийг шинэчлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх, сургалтын таатай орчинг бий болгож, Олон улсын сургалтын төвийн стандарт нийцсэн байна.</p>	<p>Нисэхийн сургалтын төвийн сургалтын техник, тоног төхөөрөмж технологийг шинэчлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх, сургалтын таатай орчинг бий болгож, Олон улсын сургалтын төвийн стандарт нийцсэн байна.</p>	<p>Нисэхийн сургалтын төвийн сургалтын техник, тоног төхөөрөмж технологийг шинэчлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх, сургалтын таатай орчинг бий болгож, Олон улсын сургалтын төвийн стандарт нийцсэн байна.</p>	<p>Ажлын байрны хэрэгцээ шаардлагад тулгуурласан гадаадын сертификаттай зарим сургалтуудыг жилд 2-оос доошгүй нисэхийг сургалтын төвд зохион байгуулахад бэлэн болсон байна.</p>	<p>Ажлын байрны хэрэгцээ шаардлагад тулгуурласан гадаадын сертификаттай зарим сургалтуудыг жилд 2-оос доошгүй нисэхийг сургалтын төвд зохион байгуулдаг болсон байна.</p>

6	Нисэхийн мэргэжил сурталчлах өдөрлөгийг 2017 оноос жилд 1 удаа идэвхтэй зохион байгуулж байна.	Нисэхийн мэргэжил сурталчлах, олон нийтэд таниулах ажлыг бүр зохион байгуулсан байна.	Нисэхийн мэргэжил сурталчлах, олон нийтэд таниулах ажлыг 1-2 удаа зохион байгуулсан байна.	Нисэхийн мэргэжил сурталчлах, олон нийтэд таниулах ажлыг 1-2 удаа зохион байгуулсан байна.	Нисэхийн мэргэжил сурталчлах, олон нийтэд таниулах ажлыг 1-2 удаа зохион байгуулсан байна.	Нисэхийн мэргэжил сурталчлах, олон нийтэд таниулах ажлыг 1-2 удаа зохион байгуулсан байна.	Нисэхийн мэргэжил сурталчлах, олон нийтэд таниулах ажлыг 1-2 удаа зохион байгуулсан байна.
---	--	---	--	--	--	--	--

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, САНХҮҮЖИЛТ

5.1 Хөтөлбөрийг 2020-2024 онд хэрэгжүүлнэ.

5.2 Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:

- Засгийн газрын тэтгэлэг
- ИНЕГ-ын тухайн жилийн батлагдсан төсөв
- Олон улсын төсөл, хөтөлбөр
- Бусад

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

6.1 Хөтөлбөрийн дагуу авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээг 2 жилд нэг удаа ИНЕГ-ын дотоод хяналт хариуцсан нэгж нь хийж удирдлагад танилцуулна.

6.2 Хөтөлбөрийн хэрэгжилт, тайланг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан ИНЕГ-ын Захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж нь хийж удирдлагад танилцуулна.

6.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар байгууллагын удирдлага, ажилтнууд тодорхой санал хүсэлт гаргаж болох ба хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, ажилтны санал хүсэлтийг үндэслэн тодотгол хийж, нэмэлт өөрчлөлт оруулж болно.